



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 4/129

Батноров сум

Архи согтууруулах ундаа худалдахыг  
хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн А/468 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлага 2024 оны 10 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулагдахтай холбогдуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2024 оны 10 дугаар сарын 05-ны өдөр суманд худалдаа үйлчилгээ эрхэлдэг тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдийг архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Хэсгийн төлөөлөгч (Г.Ганбаяр)-д даалгасугай.



Б.ЖАВХЛАНБАЯР

230423295